



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 02 сарын 05 өдөр

Дугаар А/187

Арвайхээр сум

**Газар ашиглалтын зориулалтад
өөрчлөлт оруулах тухай**

Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, Захиргааны ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн А/187 дугаар тушаалаар батлагдсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 8.1.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр сумын 13 дугаар баг, П.Лувсандорж-2 гудамж, 219 тоотод байрлах Дашдоржийн Доржсүрэнгийн (СФ77062917) эзэмшил амины орон сууцны зориулалттай 1400м² газрын зориулалтыг худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор, 13 дугаар баг, Төв цэнгэлдэх-3 гудамж, 315 тоотод байрлах Жанцандоржийн Жаргалсайханы (ЙЮ57101518) эзэмшил гэр, орон сууцны хашааны газрын зориулалттай 623м² газрын зориулалтыг 5-8 давхар нийтийн орон сууц, 5 дугаар баг, Д.Пүрэвдорж-3 гудамж, 303а тоотод байрлах Агийн Төмөрхуягийн (ЙЭ50071115) эзэмшил үйлдвэрлэлийн барилга, байгууламж, бусад газрын зориулалттай 337м² газрын зориулалтыг худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолборын зориулалттай болгон тус тус өөрчлөлт оруулсугай.

2. Дээрх газар эзэмших эрхэд гарсан өөрчлөлтийг газрын улсын бүртгэлд бүртгэж, гэрээг зохих журмын дагуу байгуулан, гэрчилгээ олгохыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Т.Ариунболд)-т үүрэг болгосугай.

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



И.ДОРЖСҮРЭН

6224 11 0181